

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗДТГ-ЫН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГИЙН ТУХАЙ

2010 онд аймгийн Засаг даргын Тамгын газар, төр, засгийн бодлогын зорилтууд, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах талаар төр, засгаас батлан гаргасан хууль, тогтоомж, үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрийг биелүүлэх талаар Засаг даргын өмнө хуулиар хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлсэн байна.

Тайлангийн хугацаанд аймгийн ЗДТГ дараахь томоохон ажлуудыг зохион байгуулсан нь үр дүнтэй болжээ.

1. Төр, засгийн бодлогын болон үйл ажиллагааны зорилтуудыг хэрэгжүүлэх асуудлуудыг сум, агентлагуудын хэтийн болон жилийн төлөвлөгөө, төрийн албан хаагчдын ажил үүргийн хуваарьт холбогдох чиглэл тус бүрээр нь тусган өгч хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажилласнаар төр, засаг, захиргааны бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоо эрс сайжирсан байна.

2. Сум, агентлаг, байгууллагуудын байнга хяналтандаа байлгаж, гардан хариуцаж хийх ажлын хуваарь гаргаж, хэрэгжилтийг нь тогтмол хянасан.

3. Аймаг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулан ИТХ-аар хэлэлцүүлэн хэрэгжүүлж байгаагийн дээр сум бүрийг ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ төлөвлөгөөтэй болгосон.

4. Сум, агентлаг бүр бүтээлч ажлын жагсаалт гаргаж хэрэгжүүлдэг болсон.

5. Аймаг, орон нутгийн нөөц бололцоог түшиглэн зохион байгуулахад хүндрэлтэй зарим асуудлыг УИХ-ын гишүүд, Засгийн газар, зарим яам, агентлагт танилцуулан дэмжлэг тусалцааа авч хамтран ажилласан.

6. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжил, бүтээн байгуулалтын ажилд зориулан улс орон нутгийн төсвөөс болон олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн нэгжүүдээс 16,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.

7. Тус аймгийн хамгийн тулгамдсан асуудлын нэг болох жижиг үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр сүүлийн 2 жилд аж ахуйн нэгж иргэдэд 1,4 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосноор 51 жижиг үйлдвэр байгуулагдаж 3,0 мянга гаруй ажлын байр бий болгосон.

8. Төрийн бүх шатны байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй, шударга шуурхай болгох зорилгоор төрийн үйлчилгээний байгууллагуудын тайланг иргэдээр хэлэлцүүлдэг, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулдаг, нээлттэй утас ажиллуулдаг зэрэг арга барилыг хэвшүүлсний дээр татвар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээ, цагдаа, Нийгмийн даатгал зэрэг байгууллагуудад нэг цэгийн үйлчилгээ нэвтрүүлсэн.

9. Аймгийн засаг даргын батламжийн гэрээ, эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчид байгуулсан гэрээг биелүүлэх зорилгоор аймгийн Засаг дарга, сумдын болон хэрэгжүүлэгч агентлагийн дарга нартай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг зохих журмын дагуу байгуулж үр дүнг тооцож ажилласан.

10. Аймгийн ЗДТГ-аас тэргүүний сум, баг шалгаруулах, тэргүүний ажил олгогч аж ахуйн нэгж байгууллага шалгаруулах, эрүүл мэндэд ээлтэй байгууллага шалгаруулах зэрэг болзол журам гаргаж дүгнэдэг уламжлалтай болсон.

11. Аймгийн ЗДТГ төрийн албан хаагчдыг чадавхижуулах төлөвлөгөө, хөтөлбөртэй ажиллаж 2010 онд нийт сум, агентлагуудын удирдах ажилтнуудыг бүрэн гүйцэтгэх ажилтнуудын дийлэнх оонхийг төвлөрсөн болон бүсчилсэн, орон нутгийн сургалтанд хамруулж чадавхижуулах арга хэмжээ авсан.

12. Тайлангийн хугацаанд 13 сум, 20 агентлагийн ажилтай газар дээр нь танилцаж, зөвлөлгөө өгсний дээр 3 сум, 2 агентлагийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, цаашид хийх ажлын тухай арга зүйн зөвлөлгөө өгсний дээр ХШҮ-ний мөрөөр авах арга хэмжээний талаар Засаг даргын захирамж гаргуулан биелэлтэнд нь хяналт тавьж ажилласан.

Эдгээр ажлын үр дүнд аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд ахиц дэвшил гарсан байна.

Иймд аймгийн ЗДТГ нь Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор баталсан журмын 3 дугаар хавсралтранд заасан 5 багц үзүүлэлтийг 96,7 хувиар биелүүлж, 4,8 оноо авлаа.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР